



МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

2017 ХОЁРДУГААР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Урсгал ба хөрөнгийн данс 2017 оны 2 дугаар улиралд 108 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 247 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 90 сая ам.долларын ашигтай буюу гадаад валютын улсын нөөц уг дүнгээр өссөн. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -50 сая ам.доллар байна.

2016 оны 2 дугаар улирлын гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 217 сая ам.доллараар буурч, санхүүгийн дансны ашиг 59 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 1,319 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 3.9 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 34% -иар өсч 2,840 сая ам.долларт хүрсэн бөгөөд барааны худалдааны тэнцэл 525 сая ам.долларт хүрч, сүүлийн 12 улирал дараалан ашигтай гарч байна. Үүнд, нефтийн импорт 2017 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 161 сая ам.доллараар (11%), хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, бүх төрлийн автомашины импорт 220 сая ам.доллараар (15%) өссөн хэдий ч нүүрсний экспорт 982 сая ам.доллараар (45%) нэмэгдсэн нь тэнцэл ашигтай гарахад нөлөөлсөн байна.

Үйлчилгээний худалдаа

2017 оны 2 дугаар улиралд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 38%-иар буюу 164 сая ам.доллараар буурч 273 сая ам.долларт хүрсэн байна.

Энэ алдагдалын бууралтад аялал жуулчлалын үйлчилгээний алдагдал өмнөх оноос 29 сая ам.доллараар, бусад үйлчилгээний дансны алдагдал 169 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлжээ.

Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 415 сая ам.долларын алдагдалтай гарч өнгөрсөн оны мөн үеэс 87%-иар буюу 194 сая ам.доллараар өссөн.


Тайлант улиралд гадаад бонд үнэт цаасны хүүгийн төлбөрт 60 сая ам.доллар, ногдол ашигт 39 сая ам.доллар, хөрөнгө оруулагчдийн зээлийн хүүгийн төлбөрт 74 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 127 сая ам.доллар, банкууд гадаад зээл болон харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт нийт 24 сая ам.доллар тус тус төлсөн байна.

Хоёрдогч орлого


Хувийн гуйвуулга болон хандив тусламжийн орлогын хувьд 2017 оны 2 дугаар улиралд манай улс нийт 41 сая ам.доллар буюу өнгөрсөн оноос 22 сая ам.доллараар бага орлогыг хүлээн авсан байна. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан гуйвуулга өмнөх оны мөн үеэс 6.9%-иар өссөн бол гадаад руу шилжүүлсэн иргэдийн гуйвуулга 15%-иар өссөн буюу гарах урсгал илүү өссөн.
- Гадаад хандив тусламжийн орлого өмнөх оны мөн үеэс 64%-иар буурсан.


Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл



Дүрслэл 2. Барааны худалдаа



Дүрслэл 3. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 1. Хувийн гуйвуулга 2017, II улирал (улсаар, мян ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	26,195	49%	▲ 31%	1,630	8%	▼ -4%
Америк	6,987	13%	▼ -7%	2,666	12%	▼ -34%
Хятад	991	2%	▼ -66%	2,937	14%	▼ -4%
Гонг Конг	680	1%	▼ -31%	229	1%	▼ -75%
Англи	2,966	6%	▲ 183%	671	3%	▼ -41%
ОХУ	573	1%	▼ -27%	1,868	9%	▼ -3%
Сингапур	671	1%	▼ -21%	503	2%	▲ 504%
Швейцарь	-	0%	0%	-	0%	0%
Герман	1,335	3%	▼ -19%	481	2%	▼ -17%
Япон	896	2%	▼ -48%	608	3%	▲ 29%
Бусад	11,660	22%	▼ -26%	9,821	46%	▲ 20%
НИЙТ	52,953	100%		21,415	100%	

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2017 оны 2 дугаар улиралд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 355 сая ам.долларын орох урсгалтай байна. Үүнд, хөрөнгө оруулалтын орох урсгалын дүнд 540 сая ам.доллар болж, хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 185 сая ам.долларт хүрсэн байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 109 сая ам.доллараар өссөн байна. Энэ нь хөрөнгө оруулагчийн зээлийн ашиглалт өссөнтэй холбоотой байна.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг улсаар нь авч үзвэл,

- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 170 сая ам.доллараар өсч 272 сая ам.доллар,
- БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 33 сая ам.доллараар нэмэгдэж 96 сая ам.долларт хүрсэн бол,
- АНУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 30 сая ам.доллараар буурч 42 сая ам.доллар,
- Австрали улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 13 сая ам.доллараар буурч 3 сая ам.долларын урсгалтай гарсан байна.

Харин эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 2017 оны 2 дугаар улиралд уул уурхайн салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт өнгөрсөн оны гүйцэтгэлээс өссөн үзүүлэлттэй байна.

Салбаруудын хөрөнгө оруулалтын хэмжээг харьцуулбал,

- Уул уурхайн салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт 179 сая ам.доллараар,
- Санхүүгийн болон даатгалын салбарынх 7 сая ам.доллараар тус тус өссөн.
- Харин зочид буудал, байр, орон сууцны салбарт орсон хөрөнгө оруулалт 34 сая ам.доллараар,
- Үйлчилгээний бусад үйл ажиллагаа 11 сая ам.доллараар,
- Бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарынх 9 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2017 оны 2 дугаар улиралд 64 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 440 сая ам.доллараар буурсан байна.

Тайлант улирлын голлох ажил гүйлгээг дурдвал:

- Засгийн газрын дотоод үнэт цаасанд оруулсан гадаадын хөрөнгө оруулалт 82 сая ам.доллар,
- Засгийн газар бондын хүүгийн төлбөрт 58 сая ам.доллар,
- Банк ,аж ахуйн нэгж бондын хүүгийн төлбөрт 25 сая ам.долларыг төлсөн байна.

Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд санхүүгийн дээрх дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд буюу бусад бүх төрлийн зээл (арилжааны, хөнгөлөлттэй, худалдааны зэрэг), бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг.

Тайлант улиралд бусад хөрөнгө оруулалтын данс 171 сая ам.долларын алдагдалтай гарсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал тэнцэл 4507 сая ам.доллараар буурсан дүнтэй байна. Энэхүү бууралтад 2016 оны 5 сард Оюутолгой компанийн авсан 4.3 тэрбум ам.долларын зээлийн ашиглалт голлон нөлөөлсөн байна.


Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	II улирал		2017.II/16.II
		Дүн	Хувийн жин	Өөрчлөлт
1	Австрали	3.3	1%	-12.9
2	Америк	42.2	8%	-29.7
3	Англи	11.0	2%	-11.1
4	БНХАУ	96.4	18%	33.0
5	Герман	2.1	0%	-6.6
6	Голланд	1.9	0%	-1.2
7	Гонг-Конг	22.0	4%	-9.0
8	Канад	271.9	50%	170.3
9	Люксембург	19.1	4%	5.6
10	ОХУ	6.4	1%	-0.3
11	Сингапур	15.9	3%	-11.5
12	Солонгос (өмнөд)	5.2	1%	-9.6
13	Турк	2.8	1%	-1.8
14	Франц	5.2	1%	1.7
15	Япон	14.7	3%	-3.2
16	Бусад	19.5	4%	-4.2
	Нийт	539.6	100%	109.5


Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)

№	Эдийн засгийн салбар	II улирал		2017.II/16.II
		2016	2017	Өөрчлөлт
1	Барилга	12.2	8.6	-3.6
2	Боловсрол	1.0	0.1	-0.9
3	Боловсруулах үйлдвэрлэл	3.7	5.0	1.3
4	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	38.9	30.2	-8.7
5	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	50.0	15.8	-34.2
6	Мэдээлэл, холбоо	8.3	2.8	-5.5
7	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	9.4	6.8	-2.7
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	15.2	22.1	7.0
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	4.9	1.6	-3.3
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2.3	0.9	-1.4
11	Уул уурхай, олборлолт	225.9	404.4	178.5
12	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	38.8	28.3	-10.5
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	5.1	3.8	-1.4
14	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.0	0.7	-0.3
15	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1.1	2.4	1.3
16	Бусад	12.4	6.1	-6.3
	Нийт	430.1	539.6	109.5

Дүрслэл 4. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Дүрслэл 5. Бусад хөрөнгө оруулалт



II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2017 оны 2 дугаар улирлын эцэст цэвэр дүнгээр 30,469 сая ам.долларын үлдэгдэлтэй буюу өр төлбөртэй байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 3,964 сая ам.доллар байна. Үүний 49%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 33%-ийг гадаад валютын албан нөөц, 12%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 6%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 34,433.6 сая ам.долларт хүрчээ. Үүний 47%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 40%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 13%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 3%-иар буюу 940.6 сая ам.доллараар өссөн байна. Үүнийг

- ерөнхий бүтцээр авч үзвэл, гадаад актив 5%-иар буюу 224 сая ам.доллараар буурч, гадаад пассив 2%-иар буюу 716 сая ам.доллараар өссөн,
- данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц 139 сая ам.доллараар, санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн позиц 51 сая ам.доллараар гадаад валютын нөөц 23 сая ам.доллараар тус тус өссөн, харин багцын хөрөнгө оруулалтын позиц 650 сая ам.доллар, бусад хөрөнгө оруулалтын позиц 506 сая ам.доллараар тус тус буурснаар тайлбарлагдаж байна.
- позицийн өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, төлбөрийн тэнцлийн урсгалаар -157 сая, үнийн өөрчлөлтөөр -6 сая, бусад өөрчлөлтөөр -75 сая, ханшийн зөрүүгээр -63 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

Шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 56%-ийг буюу 9,110 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 44% буюу 7,172 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- БНХАУ-аас 4,701 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 29%,
- Канад улсаас 4,405 сая ам.доллар буюу 27%,
- Хонг Конг улсаас 1,434 сая ам.доллар буюу 9%,
- Сингапур улсаас 1,323 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 8%-тай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтуудыг тус тус оруулсан байна.

Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2017 оны 2 дугаар улирлын эцэст 226 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 9%-иар, харин гадаад пассивын үлдэгдэл 4,361 сая ам.долларт хүрч 18%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


Актив: эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл Гонг конг 40%, Сингапур 14%, Англи 8%, Австрали 5%-ийг тус тус эзэлж байна.

Пассив: эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал Англи 9%, Сингапур 6%, Хонг Конг 4%, бусад улс 34%, харин 37% нь эзэмшигч тодорхойгүй буюу хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа үнэт цаас эзэлж байна.


Хүснэгт 4. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	6/30/2016	6/30/2017	Өөрчлөлт	
			дүн	хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-29,529	-30,469	941	3%
I. Гадаад актив	4,188	3,964	-224	-5%
1. Шууд хөрөнгө оруулалт	444	456	13	3%
2. Багцын хөрөнгө оруулалт	207	226	19	9%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	113	38	-74	-66%
4. Бусад хөрөнгө оруулалт	2,128	1,924	-204	-10%
5. Нөөц актив	1,297	1,319	23	2%
II. Гадаад пассив	33,717	34,434	716	2%
1. Шууд хөрөнгө оруулалт	16,409	16,283	-127	-1%
2. Багцын хөрөнгө оруулалт	3,692	4,361	669	18%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	167	39	-128	-77%
4. Бусад хөрөнгө оруулалт	13,450	13,751	301	2%


Дүрслэл 6. Гадаад актив, пассив



Дүрслэл 7. Шууд ХО-ын үлдэгдэл, 2017 оны 2 дугаар улирал



Дүрслэл 8. Багцын ХО-ын үлдэгдэл, 2017 оны 2 дугаар улирал



III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өр (хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хөрөнгө оруулалтаас бусад гадаад өр төлбөр)-ийн үлдэгдэл 2017 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 25,215 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 955 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Улсын салбар: Засгийн газрын гадаад өр 1,230 сая ам.доллараар нэмэгдэж 6,016 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 113 сая ам.доллараар нэмэгдэж 1,871 сая ам.долларт хүрчээ.

Бусад салбар: Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 388 сая ам.доллараар буурч 17,328 сая ам.долларт хүрээд байна.

Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2017 оны 2 дугаар улиралд 2,270 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2%-иар буюу 55 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 40%-ийг урт хугацаат зээл, 26%-ийг бонд өрийн бичиг, 20%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 14%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 913 сая ам.доллар, 460 сая ам.долларт хүрээд байна.

Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2017 оны 2 дугаар улирлын эцэст 15,058 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 68 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Салбарын нийт зээлийн 48% буюу 7,172 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.


Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.

Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 218 сая ам.доллар болсон байна.


Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	6/30/2016	6/30/2017	өөрчлөлт		* %
			дүн	хувь	
Нийт гадаад өр	24,260	25,215	955.33	4%	100%
I. Засгийн газар	4,786	6,016	1,230	26%	24%
II. Төв банк	1,758	1,871	113	6%	7%
III. Банк	2,216	2,270.2	55	2%	9%
Богино хугацаат	465	460.2	-4	-1%	2%
Урт хугацаат	1,751	1,810	59	3%	7%
IV. Бусад сектор	8,304	7,885	-419	-5%	31%
Богино хугацаат	518	488	-30	-6%	2%
Урт хугацаат	7,786	7,397	-389	-5%	29%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	7,196	7,172	-23	0%	28%

Дүрслэл 9. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 10. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2010	12/31/2011	12/31/2012	12/31/2013	12/31/2014	12/31/2015	12/30/2016	3/31/2017	6/30/2017
Засгийн газар	1,882.2	2,043.3	3,599.3	3,534.6	3,500.8	3,759.9	4,868.6	5,844.6	6,016.2
Төвбанк	273.6	267.7	571.5	1,130.5	1,570.4	1,959.6	1,790.8	1,741.0	1,870.8
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	512.0	739.8	1,176.0	1,375.8	1,762.2	2,128.5	2,417.4	2,382.5	2,270.2
Бусад салбарууд	1,474.3	1,904.7	2,836.1	3,198.7	3,976.6	3,748.9	8,121.5	7,464.4	7,885.2
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	2,985.7	5,952.8	9,027.6	10,590.1	11,040.6	11,120.9	7,426.3	7,525.0	7,172.5
Нийт гадаад өр	7,127.8	10,908.3	17,210.5	19,829.7	21,850.5	22,717.8	24,624.5	24,957.4	25,214.9